

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн .....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	7
2.12. Шилэн дансны мэдээлэл .....	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	7
3 Менежментийн захидал .....	8
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	10
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	10
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	11
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	13
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	15
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	16
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	17
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	18

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ШУА	Шинжлэх ухааны академи



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

2020.08.06 № 06/738  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Археологийн хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Археологийн хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Археологийн хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага


Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



## **2.Аудитын тайлан**

### **2.1. Оршил**

Археологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг захирал Г.Эрэгзэн Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн ашиглалтгүй хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх, археологийн олдворуудыг үнэлүүлж, санхүүгийн тайланд тусгах, авлага өглөг үүсгэхгүй байх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### **2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Археологийн хүрээлэнгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Археологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 2 дугаар сарын 08-наас 2020 оны 02 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Ниямазон аудит” ХХК-ийн аудитор Т.Оюун, аудиторын туслах Ж.Ариунаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Археологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 01/39 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

## **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Археологийн хүрээлэн нь зорилгоо “Монгол улсад археологийн шинжлэх ухааныг хөгжүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг дэлхийн жишгээр явуулж, иновацийг бий болгож үр дүнг практикт нэвтрүүлэх, шинжлэх ухааны орчин үеийн ололт амжилтыг түгээн дэлгэрүүлэх” гэж тодорхойлсон байна.

Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгчийн 2019 оны А/152 дугаар тушаалын 7 дугаар хавсалтаар Археологийн хүрээлэнгийн дүрмийг баталж үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- холбогдох салбарын онолын суурь судалгаа явуулж, захиалгат болон хамтарсан төслүүдийг гүйцэтгэх замаар судалгаа-боловсруулалтын ажлын үр дүнг шинжлэх ухаанд болон практикт нэвтрүүлэх;
- бусад эрдэм шинжилгээний байгууллага, их, дээд сургуульд хийгдэж байгаа судалгаа шинжилгээний болон сургалтын ажилд оролцох, эрдэмтдийн залуу халааг бэлтгэх;
- олон улс, бүс нутаг, гадаад орнуудын болон дотоодын аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран судалгаа шинжилгээний ажил хийх, түүний үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, худалдах, патентлах, олон улсын байгууллага болон гадаад орнуудаас эрдэмтэн мэргэжилтэн урьж хамтарч ажиллах, өөрийн эрдэмтэн мэргэжилтнийг гадаад орнуудад явуулах асуудлыг шийдвэрлэх;
- олон улсын болон дотоодын эрдэм шинжилгээний хурал, симпозиум, сургалт, семинар, хээрийн экскурс зохион байгуулах, ном бүтээл хэвлэх;
- зохих зөвшөөрлийн дагуу дангаараа болон бусад байгууллагатай хамтран туршилт-үйлдвэрлэлийн түшиц цех, нэгж байгуулах, шинжилгээ судалгааны ажлын онол, арга зүйн түвшинг дээшлүүлж үйлдвэрлэл практикт нэвтрүүлэх ажлын зохицуулалт хийх;
- эрдэм шинжилгээний ажлын үр дүнд үндэслэн ШУА-ийн Их, Бага чуулганаар уламжлан төр засгийн байгууллагад санал, зөвлөмж оруулах, үйл ажиллагааныхаа тайланг тогтоосон хугацаанд ШУА-ийн Тэргүүлэгчдийн газарт тайлагнах гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд томоохон өөрчлөлт ороогүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус хүрээлэнгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Археологийн хүрээлэнгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Археологийн хүрээлэн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Acolous програм хангамж ашигладаг байна.

Археологийн хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

## 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Археологийн хүрээлэнгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 7 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 517,964.3 мянган төгрөгөөс тооцон 5,179.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг өөрчлөөгүй болно.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Засгийн газрын 2019 оны 328 дугаар тогтоолоор Археологийн хүрээлэнг шинэчлэн зохион байгуулж, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 430 дугаар тогтоолоор Түүх, археологийн хүрээлэнгээс нийт 364,876.6 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсан байна.

2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүнд авлага 2.0 хувь, бараа материал 8.0 хувь, үндсэн хөрөнгө 90.0 хувь эзэлж байна.

Хүснэгт 2. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөгөөр/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	0.0	7,815.5	7,815.5
Бараа материал	0.0	27,219.3	27,219.3
Үндсэн хөрөнгө	0.0	349,741.6	349,741.6
Хуримтлагдсан элэгдэл	0.0	(3,026.9)	(3,026.9)
<b>Нийт хөрөнгө</b>	0.0	<b>381,749.5</b>	<b>381,749.5</b>
Өр төлбөр	0.0	843.4	843.4
Өмч	0.0	342,891.6	342,891.6
Хуримтлагдсан үр дүн	0.0	38,014.5	38,014.5
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	0.0	<b>381,749.5</b>	<b>381,749.5</b>

Авлагын данс 7,815.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 3,279.7 мянган, төрийн сангийн нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулаагүй үлдэгдэл хураалгаснаас үүссэн 4,535.8 мянган төгрөгийн авлагаас бүрдэж байна.

Бараа материалын дансанд үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 21,984.0 мянга, худалдан авсан 30,117.5 мянга, нийт 52,101.5 мянган төгрөгийн орлогын гүйлгээ хийгдэж, 24,882.3 мянган төгрөгийн бараа материалыг зарлагдсан байна.

Тайлант хугацаанд 6,850.0 мянган төгрөгийн биет болон биет бус хөрөнгө худалдан авсан.

Өр төлбөр дансанд 843.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь цалингаас төлөх үйлдвэрчний эвлэлийн татварын өглөг байна.

## **2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Археологийн хүрээлэн тайлант онд улсын төсвөөс 202,741.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал зардалд 202,741.1 мянган төгрөг зарцуулж, 0.06 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### **Нэмэлт төсөв:**

Соёлын өвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.8-д “хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, газар тариалан эрхлэх, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгохоос өмнө палеонтологи, археологи, угсаатны мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулна” гэж заасны дагуу тус хүрээлэн 52 аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтээр авран хамгаалах хайгуул судалгааны ажил хийж 242,575.5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас 88,678.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зардалд 326,142.5 мянган төгрөг зарцуулж, 5,111.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. Үүнээс 3,692.4 мянган төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

## **2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тодорхойлсон 7 эрсдэлд нийт 11 горим сорил хэрэгжүүллээ. Аудитаар 4,123.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## **2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Археологийн хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар авран хамгаалах ажиллагаатай холбоотой бүртгэлийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

## **2.12. Шилэн дансны мэдээлэл**

Археологийн хүрээлэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хугацаа хоцроож өссөн дүнгээр 2019 оны 12 дугаар сард байршуулсан байна.

## **2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт**

Тайлант онд байгуулагдсан тул өмнөх онд санхүүгийн тайлангийн аудит хийгдээгүй байна.

## **2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Археологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Археологийн хүрээлэнгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



### 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 1. *Балансын данстай холбоотой асуудал*

##### 1.1. Илрүүлэлт:

Аудитын явцад хийсэн хяналтын тооллогоор үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 18 нэр төрлийн 24 ширхэг хөрөнгө эвдрэлтэй, ашиглах боломжгүй болсон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 6 дугаар зүйлийн 6.2-т заасантай нийцэхгүй байна.

##### 1.2. Эрсдэл:

Тайлант үеийн үндсэн хөрөнгө буруу илэрхийлэгдэх

##### 1.3. Өгсөн зөвлөмж:

Ашиглалтгүй, эвдэрхий, элэгдлээрээ өртгөө нөхсөн дээрх хөрөнгийн асуудлыг байгууллагын өмч хамгаалах зөвлөл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлэх

##### 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

#### 2. *Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал*

##### 2.1. Илрүүлэлт:

Тус хүрээлэнгийн сан хөмрөгт 1420 дэсийн 8572 ширхэг олдвор, эх хэрэглэгдэхүүн хадгалагдаж байгаа бөгөөд Соёлын өвийн тухай хуулийн дагуу улсын бүртгэл мэдээллийн санд бүртгэгдсэн эдгээр олдворыг санхүүгийн тайлан бүртгэлд тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

### 2.3. Өгсөн зөвлөмж:

Археологийн олдворуудыг мэргэжлийн байгууллагаар үнэлүүлж, санхүүгийн тайланд тусгах

### 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

## **3. Балансны данстай холбоотой асуудал**

### 3.1. Илрүүлэлт:

Нийгмийн даатгалын шимтгэлд 3,279.7 мянган төгрөг илүү шилжүүлж авлага үүсгэсэн, цалинг суутгасан үйлдвэрчний эвлэлийн татварт 843.4 мянган төгрөг дутуу шилжүүлж өглөг үүсгэсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасантай нийцэхгүй байна.

### 3.2. Эрсдэл:

Төсвийн хууль зөрчигдөх

### 3.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасны дагуу төсвийг зохистой удирдаж, авлага өглөг үүсгэх байх

### 3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>0.0</b>	<b><u>35,034,768.92</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	0.0	7,815,489.11
33300	Татаас, санхүүжилтийн авлага	0.0	4,535,800.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	0.0	3,279,689.11
3351	Байгууллагаас авах авлага	0.0	3,279,689.11
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	0.0	27,219,279.81
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	0.0	2,108,999.98
35110	Тусгай зориулалттай материал	0.0	2,108,999.98
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	0.0	25,110,279.83
35410	Бичиг хэргийн материал	0.0	3,713,801.00
35420	Аж ахуйн материал	0.0	11,479,933.00
35430	Сэлбэг хэрэгсэл	0.0	253,000.00
35470	Бусад хангамжийн материал	0.0	9,663,545.83
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>0.0</b>	<b><u>346,714,771.78</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	0.0	346,714,771.78
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	0.0	304,653,105.11
39201	Барилга, байгууламж, орон сууц	0.0	270,338,517.70
39202	Хуримтлагдсан элэгдэл	0.0	(1,802,256.76)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	0.0	28,186,536.89
39204	Хуримтлагдсан элэгдэл	0.0	(1,069,955.83)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	0.0	3,659,280.65
39208	Хуримтлагдсан элэгдэл	0.0	(136,317.00)
39217	Ном	0.0	5,477,299.50
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	0.0	42,061,666.67
39301	Програм хангамж	0.0	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	0.0	(18,333.33)
39303	Бусад биет бус хөрөнгө	0.0	41,200,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>0.0</b>	<b><u>381,749,540.70</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	0.0	<b><u>843,360.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	0.0	843,360.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	0.0	843,360.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	0.0	843,360.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.0	843,360.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>0.0</b>	<b><u>380,906,180.70</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	0.0	342,891,634.74
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	0.0	342,891,634.74
51101	Өмч: - төрийн	0.0	342,891,634.74
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	0.0	38,014,545.96
51210	Өмнөх үеийн үр дүн	0.0	(342,891,634.74)
51220	Тайлант үеийн үр дүн	0.0	380,906,180.70
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>		<b><u>381,749,540.70</u></b>

#### 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>0.0</b>	<b>898,870,512.52</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>0.0</b>	<b>364,875,640.55</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	0.0	364,875,640.55
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.0	364,875,640.55
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.0	364,875,640.55
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>0.0</b>	<b>533,994,871.97</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	0.0	<b>202,741,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.0	202,741,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	0.0	<b>331,253,671.97</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.0	88,678,100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.0	242,575,571.97
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>0.0</b>	<b>517,964,331.82</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>0.0</b>	<b>516,545,570.70</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>0.0</b>	<b>516,545,570.70</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	0.0	312,911,742.25
210101	Үндсэн цалин	0.0	242,688,540.25
210102	Нэмэгдэл	0.0	8,399,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.0	61,824,002.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	0.0	<b>27,954,714.89</b>
210201	Тэтгэврийн даатгал	0.0	20,881,882.92
210202	Тэтгэмжийн даатгал	0.0	1,768,208.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.0	1,414,566.18
210204	Ажилгүйдлийн даатгал	0.0	353,641.36
210205	Эрүүл мэндийн даатгал	0.0	3,536,415.95
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	0.0	<b>27,363,832.00</b>
210402	Тээвэр, шатахуун	0.0	24,882,260.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.0	81,572.00
210404	Ном, хэвлэл	0.0	2,400,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	0.0	<b>22,071,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	0.0	21,371,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	0.0	700,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>0.0</b>	<b>123,217,418.60</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.0	123,217,418.60
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	0.0	<b>3,026,862.96</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	0.0	3,026,862.96
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>0.0</b>	<b>1,418,761.12</b>

Археологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	0.0	1,418,761.12
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	60.75
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	1,418,700.37
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>0.0</b>	<b><u>380,906,180.70</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>0.0</b>	<b><u>380,906,180.70</u></b>

### 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>0.0</b>	<b><u>534,838,231.97</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>0.0</b>	<b>843,360.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	0.0	843,360.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.0	843,360.00
120009	Бусад орлого	0.0	843,360.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>0.0</b>	<b>533,994,871.97</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	0.0	<b>202,741,200.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.0	202,741,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	0.0	<b>331,253,671.97</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.0	88,678,100.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.0	242,575,571.97
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>0.0</b>	<b><u>465,464,229.97</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>0.0</b>	<b>459,509,668.85</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>0.0</b>	<b>459,509,668.85</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	0.0	<b>251,510,698.25</b>
210101	Үндсэн цалин	0.0	242,688,540.25
210102	Нэмэгдэл	0.0	8,822,158.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.0	61,824,002.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	0.0	<b>31,234,404.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	0.0	24,161,572.03
210202	Тэтгэмжийн даатгал	0.0	1,768,208.48
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.0	1,414,566.18
210204	Ажилгүйдлийн даатгал	0.0	353,641.36
210205	Эрүүл мэндийн даатгал	0.0	3,536,415.95
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	0.0	<b>21,567,094.00</b>
210401	Бичиг хэрэг	0.0	2,738,622.00
210402	Тээвэр, шатахуун	0.0	15,907,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0.0	81,572.00
210404	Ном, хэвлэл	0.0	2,400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.0	439,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	0.0	<b>403,979.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.0	403,979.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	0.0	<b>21,371,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	0.0	21,371,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>0.0</b>	<b>125,196,549.60</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.0	125,196,549.60
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	0.0	<b>8,225,944.00</b>

Археологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.0	8,225,944.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>0.0</b>	<b>5,954,561.12</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>0.0</b>	<b>5,954,561.12</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	843,420.75
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		5,111,140.37
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>0.0</b>	<b><u>69,374,002.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>0.0</b>	<b>6,850,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>0.0</b>	<b>6,850,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>0.0</b>	<b>6,850,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан	0.0	6,850,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>0.0</b>	<b><u>(6,850,000.00)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>0.0</b>	<b>0.0</b>

#### 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>		<b>0.00</b>	<b>0.00</b>
Тайлант үеийн үр дүн			0.0	0.0
<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>0.00</b>		<b>0.00</b>	<b>0.00</b>
Үндсэн хөрөнгийн өсөлт,	342,891,634.74		(342,891,634.74)	0.00
Тайлант үеийн үр дүн			380,906,180.70	380,906,180.70
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>342,891,634.74</b>		<b>38,014,546.00</b>	<b>380,906,180.70</b>



#### 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>201,461,200.00</b>	<b>202,741,139.25</b>	<b>(1,279,939.25)</b>	100.6
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	201,461,200.00	202,741,139.25	(1,279,939.25)	100.6
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>201,461,200.00</b>	<b>202,741,139.25</b>	<b>(1,279,939.25)</b>	100.6
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	176,978,600.00	176,978,545.25	54.75	100.0
Үндсэн цалин	132,018,700.00	168,156,387.25	(36,137,687.25)	127.4
Нэмэгдэл	44,959,900.00	8,822,158.00	36,137,742.00	19.6
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>22,102,600.00</b>	<b>22,102,600.00</b>	<b>0.00</b>	100.0
Тэтгэврийн даатгал	18,618,000.00	15,029,768.03	3,588,231.97	80.7
Тэтгэмжийн даатгал	871,200.00	1,768,208.48	(897,008.48)	203.0
ҮОМШӨ-ний даатгал	696,900.00	1,414,566.18	(717,666.18)	203.0
Ажилгүйдлийн даатгал	174,200.00	353,641.36	(179,441.36)	203.0
Эрүүл мэндийн даатгал	1,742,300.00	3,536,415.95	(1,794,115.95)	203.0
<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>1,100,000.00</b>	<b>1,099,994.00</b>	<b>6.00</b>	100.0
Бичиг хэрэг	300,000.00	578,622.00	(278,622.00)	192.9
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	400,000.00	81,572.00	318,428.00	20.4
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	400,000.00	439,800.00	(39,800.00)	110.0
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,280,000.00</b>	<b>2,560,000.00</b>	<b>(1,280,000.00)</b>	200.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,280,000.00	2,560,000.00	(1,280,000.00)	200.0
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>202,741,200.00</b>	<b>202,741,139.25</b>	<b>60.75</b>	100.0
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>202,741,200.00</b>	<b>202,741,139.25</b>	<b>60.75</b>	100.0
Улсын төсвөөс санхүүжих	202,741,200.00	202,741,139.25	60.75	100.0
<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>43</b>	<b>43</b>		100.0
Удирдах ажилтан	1	1		100.0
Гүйцэтгэх ажилтан	41	41		100.0
Үйлчлэх ажилтан	1	1		100.0

#### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>331,253,671.97</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>331,253,671.97</b>
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>326,142,531.60</b>
<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>		136,356,155.00
Үндсэн цалин		74,532,153.00
Гэрээт ажлын хөлс		61,824,002.00
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх</b>		<b>9,131,804.00</b>
Тэтгэврийн даатгал		9,131,804.00
<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>20,467,100.00</b>
Бичиг хэрэг		2,160,000.00
Тээвэр, шатахуун		15,907,100.00
Ном, хэвлэл		2,400,000.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>6,373,979.00</b>
Багаж, техник, хэрэгсэл		6,373,979.00
<b>Томилолт, зочны зардал</b>		<b>22,071,000.00</b>
Дотоод албан томилолт		21,371,000.00
Зочин төлөөлөгч хүлээн авах		700,000.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>122,636,549.60</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		122,636,549.60
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>9,105,944.00</b>
Бараа үйлчилгээний бусад зардал		9,105,944.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>5,111,140.37</b>
<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>		<b>5,111,140.37</b>
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		5,111,140.37
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>331,253,671.97</b>
<b>НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>		<b>331,253,671.97</b>
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		88,678,100.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		242,575,571.97

## 5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	<b>Археологийн хүрээлэнгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2020.02.25			САГ-2020/163/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Археологийн хүрээлэн		Мянган төгрөгөөр

Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
		Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5
Ашиглалтгүй, эвдэрхий, элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгийн үлдэгдэлтэй болохоор байна.		Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Ц.Хатанбаатар
1407 ширхэг Археологийн олдворыг үнэлэх асуудлыг мөнгөөр үнэлж бүртгэх		Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Ц.Хатанбаатар
Нийгмийн даатгалын шимтгэлд 3,279.7 мянган төгрөг илүү шилжүүлж авлага, Үйлдвэрчний эвлэлийн татварт 843.4 мянган төгрөг дутуу шилжүүлж өглөг үүсгэсэн.	4,123.1	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Ц.Хатанбаатар
<b>Дүн</b>	<b>4,123.1</b>			

